ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 25 өдөр Дугаар А/77 Арвайхээр сум

Өндөр гэгээн Занабазарын музейг засварлах
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Өндөр гэгээн Занабазарын музейг засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:Ж.Ганзориг (Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга: М.Эрдэнэчимэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд:Ч.Сайнчулуун (Иргэний төлөөлөл, зөвшилцсөнөөр)

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг цахим хэлбэрээр холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн барихыг үнэлгээний хорооны дарга (Ж.Ганзориг)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Эрдэнэчимэг)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/26 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:2024/Alban bichig/Zahiramj-2024

82241181